

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2022 оны 5 сарын 19-ний өдөр

Тендерийн нэр: Дулааны өргөлтийн 18-р насосны станцын барилгын өргөтгөл барих ажлын зураг, төсөв
Тендер дугаар: МРЦМ/202212213

“Монголросцветмет” ТӨҮГазар Хэнтий аймгийн “Бор-Өндөр” сумын нутаг дэвсгэрт байх дулааны өргөлтийн 18-р насосны станцын барилгын өргөтгөл барих ажлын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан талаарх дараах нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2019, 2020, 2021 онуудын аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна.
- Голлох мэргэжилтний чадавхийн талаарх мэдээлэл: Ажиллах боловсон хүчний ур чадвар, мэргэшил, туршлага
- Татвар, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд (татварын дутуу төлөлт өргүй болон өр төлбөргүй байх)
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2019, 2020, 2021 (Сүүлийн гурван жилд ижил төстэй хийж гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээний ажлыг жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын дагуу олгогдсон тусгай зөвшөөрөлтэй байх.

Чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөхүүд түншлэл, туслан гүйцэтгэгчийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс авч болох бөгөөд тендерийн нэмэлт мэдээлэл, тодруулгыг Захиалагч www.tender.gov.mn хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна. Тендерт оролцогч мэдүүлгээ **2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 10:00 цагаас** өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГАЗАР